



## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 64

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.
- 2."Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:
  - 1/"Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2010 оны 1 дүгээр улиралд багтаан батлах;
  - 2/"Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.
- 3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**